

**“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ӨНДӨР ХУРДНЫ ИНТЕРНЕТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ” ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолт нь Иргэний нисэхийн ерөнхий газарт өндөр хурдны интернетийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтүүдийг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Тухайн интернет урсгалын холболт хийж үйлчилгээ үзүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангаж, бүрэн нийцсэн байна.

д/д	Нэр төрөл	Тавигдах шаардлага
1	Олон улсын гарц	Бие биенээсээ үл хамаарах үндсэн, нөөц гарцтай байх ба АНУ, Европ, Азийн үндсэн урсгалын зангилаа төвүүд рүү шууд хандалттай байх
2	Олон улсын гарцын холболт	Аль нэг чиглэлд интернет порт болон шилэн кабелийн сүлжээнд гэмтэл гарах үед автоматаар нөгөө чиглэл рүү шилжих 1+1 Best Path Back up BW хамгаалалттай.
3	Холболтын төрөл, протокол	Шилэн кабель, BGP протоколоор холбогдох бүрэн боломжтой байх.
4	Холболтын хурд	156Mbps (dedicated) буюу түүнээс дээш хурдны үзүүлэлттэй байх
5	Холболт хийх байршил	Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төв байрны 4-р давхарт байрлах. ИНЕГ-ын тоног төхөөрөмжийн зогсуурт холбох
6	Холболтын интерфэйс	Нийлүүлэгч тал болон ИНЕГ хооронд үндсэн нөөц холболтыг яармаг чиглэлийн шилэн кабелаар, нөөц холболтыг Сонсголон чиглэлийн шилэн кабелаар хийх порттой байх. 40км зайд GBIC модулиар дамжуулах техникийн шийдэлтэй байна.
7	Техникийн үйлчилгээ	7 хоног, 24 цагийн техникийн үйлчилгээ үзүүлэх, хамтарч ажиллах.
8	Хяналт	Үндсэн интернет урсгалын хяналтыг нийлүүлэгч талаас хянах /PRTG&MRTG, Sacti...../ хэрэглэгчийн эрхийг Холбоо, навигаци, ажиглалтын албаны хариуцсан инженерт нээж өгөх.
9	Тусгай зөвшөөрөл	Албан ёсны интернетийн бөөний үйлчилгээ үзүүлэх А ангиллын тусгай зөвшөөрөлтэй байх. Сүүлийн 3 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх.
10	Халдлагаас хамгаалах систем	Ddos болон бусад халдлагаас хамгаалагдах, тэдгээрийн тайланг тогтмол авах боломжтой байх
11	Интернетийн гарц	Ямар нэг контент нөөцлөх системээр дамжихгүй байх.
12	Интернет урсгалын хурдыг нэмэгдүүлэх болон багасгах	Ажлын 1 өдөрт шийдвэрлэж өгч байх

13	Монгол улсаас гарах нөөц холболтын шаардлага	Аль нэг гадаад гарц унасан тохиолдолд нөөц холболт нь үндсэн урсгалыг бүрэн даах чадвартай байх ба энэ шаардлагыг биелүүлэх техникийн шийдэлтэй байх, танилцуулга ирүүлэх.
----	--	--

3. БАРИМТ БИЧИГ

Дараах бичиг баримтуудыг хавсаргасан байна.

- Албан ёсны интернетийн бөөний үйлчилгээ үзүүлэх А ангиллын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
- Өөрийн байгууллагын үйлчилгээний танилцуулга
- Холболтын диаграм зураг

4. ХОЛБОЛТ

Интернет урсгалын холболтын ажил хийгдсэний дараа ажиллагааг шалгах тестийг Иргэний нисэхийн ерөнхий газар дээр 7 хоногийн турш хийнэ. Шалгах ажиллагааг амжилттай болсны дараа ИНЕГ, нийлүүлэгч эцсийн интернет үйлчилгээ үзүүлэх гэрээнд гарын үсгээ харилцан зурна.

5. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВААРЬ:

№	Хийгдэх үйлчилгээ	Огноо
1	Туршилт шалгалт эхлэх	2020.12.16
2	Үндсэн сүлжээг холбож үйлчилгээ эхлэх	2020.12.25
3	Үйлчилгээг дуусгах	2021.12.25

6. НИЙЛҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн өндөр хурдны интернетийн бөөний үйлчилгээ үзүүлэх ба холболтын ажлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын Холбоо, навигаци, ажиглалтын албаны инженер, техникийн ажилтнуудтай хамтран гүйцэтгэнэ.

Нийлүүлэгч нь тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг 24/7 байнгын бэлэн байдалд хангаж ажилладаг байна.

Нийлүүлэгч нь өөрийн талын шаардлагатай холболтын тоног төхөөрөмж болон дагалдах хэрэгсэл (Router, module)-ийг хангаж ажиллана.